



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/193

Эрдэнэт

Г

Хөрөнгө гаргах тухай

Г

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3а, 29,2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.8, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны сэг зэмээр байгаль орчин бохирлогдож хүн малын халдварт өвчин гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн малчдын байршиж байгаа нутаг дэвсгэрт хорогдсон малын сэг зэмийг устгах, хашаа хороо, өтөг бууц, бэлчээр, худаг ус, булаг шандыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардлын хавсралтаар баталсугай.

2. Аймгийн нийт малчдын байршиж байгаа нутаг дэвсгэр дэх хорогдсон малын сэг зэмийг устгах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг 2017 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны хооронд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохих журмын дагуу зохион байгуулж дуусган, цаашид хорогдсон малын сэг зэмийг малчид, иргэдийн хүчээр цаг тухай бүрт нь устгаж халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал, амьтны сэг зэм устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хийх заавар, зөвлөмж боловсруулан, үйл ажиллагааны явцад үзлэг, тандалт хийж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Онцгой байдлын газар /н.Ганбаатар/, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /н.Жигдэнгомбо/, Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргалд тус тус даалгасугай.

5. Мал амьтны сэг зэм устгах, өвөлжөө хаваржааны ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах 6920000 төгрөг /зургаан сая есөн зуун хорин мянган / төгрөгийг “Болзошгүй аваар”-ийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0946

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын  
 ...-ны өдрийн ... дугаар захирамжийн хавсралт



МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАХ, АРИУТГАЛ  
 ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ШААРДАГДАХ  
 ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Марк	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо хэмжээ	Бүгд Үнэ /төг/	Тайлбар
1	Шатахууны зардал	A/80	литр	1480	1500	2220000	Сэг зэм тээвэрлэх, булж устгах зардал
2	Ковш /нүх ухах, булж устгах/	ДТ түлш	литр	1780	900	1602000	
3	Ариутгалын бодис хүргэлт, устгалын ажлын гүйцэтгэлд хяналт тавих	A/80	литр	1480	350	518000	
	Шатахууны дүн					4344000	
3	Хоол, хөдөлмөр хамгааллын хувцас	Томилолт	Хүн /өдөр	12000	20*10	2400000	Сэг зэм устгах туслах ажилтан-5, Жолооч -5, Малын эмч-10
		Ажлын бээлий	ш	800	100	80000	
4	Усны үнэ		төг	2	50000	100000	
	<b>Дүн</b>					<b>6920000</b>	